

## 1. Төслийн товч танилцуулга

НИК ХХК-ний Орхон НХС-ын харьяа ГТБ-ний Эрдэнэт агуулах нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан баг Вокзалын зүүн талд байрлалтай. Тус агуулах нь Орхон аймгийн Засаг даргын захирамжаар 25474м<sup>2</sup> талбай эзэмшдэг ба 1995 онд ашиглалтанд орсон.

ГТБ-ний агуулах нь А-80, Аи92, Аи95, Дт, Евро Дт болон тос тосолгооны матриалыг хүлээн авч зоиулалтын саванд шатахууныг нөөцлөн хадгалдаг. Эрдэнэт агуулахаас бөөнөөр болон жижиглэнгээр автоцистернд ачилт хийж Орхон, Булган, Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ аймаг болон сумдуудын ШТС-уудыг шатахуунаар хангадаг. Агуулах нь нийт 7 ажилтантай. Агуулахын эрхлэгч, нярав,лаборант-2, экспедитор, насосчин, ачигч буулгагч гэсэн 7 орон тоотойгоор ажилладаг.

Тус агуулах нь 500м<sup>3</sup>-ын 2 ширхэг, 250м<sup>3</sup>-ын 2 ширхэг, 700м<sup>3</sup>-ын 3 ширхэг, 400м<sup>3</sup>-ын 3 ширхэг, 50м<sup>3</sup>-ын 2 ширхэг нийт 5000м<sup>3</sup>-ийн 12 ширхэг ил савтай. Автоцистернд ачих 6 зориулалтын ачих эстакадтай ба 6 вагон зэрэг хүлээн авах төхөөрөмжтэй.

Агуулах нь төвийн цахилгааны нэгдсэн сүлжээнд холбогдсон, ажлын байр нь зориулалтын цахилгаан халаалтаар халдаг.

Ажилчид унданд зөөврийн усаар хангагддаг. Галын аюул осол гарсан үед ашиглах гүний худагтай. Мөн галын аюул ослын үед ашиглах 500м<sup>3</sup>-ийн усны нөөцтэй, 2 тонн галын осол гарсан үед ашиглах зориулалтын хөөс болон бусад гал унтраах хэрэгслэл байрлуулсан.

Агуулахын сав парк, зам талбай бүхэлдээ бетон хучилттай ба сүүлийн үеийн лед гэрэлтүүлэг, аянга зайлуулагч анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, галын анхан шатны багаж хэрэгслэл, сав паркийн далан, хяналтын камержуулалт, бусад тоног төхөөрөмжийг суурьлуулсан болно.



**2.Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт:**

1. Нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах явцад үүсэх сөрөг нөлөөлөл.
2. Нефтийн бүтээгдэхүүнийг дамжуулах шугам хоолой, технологийн багаж тоног төхөөрөмжөөс үүсэх сөрөг нөлөөлөл.
3. Нефтийн бүтээгдэхүүнийг ачих, буулгах, тээвэрлэх үед үүсэж болох сөрөг нөлөөлөл.
4. Нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, дамжуулах технологийг зөрчсөнөөс үүсэж болох сөрөг нөлөөлөл.
5. ШТС-ын үйлчилгээний дэд системүүдээс үзүүлэх сөрөг нөлөөлөл.
6. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.
7. Усан орчинд үзүүлэх голлох сөрөг нөлөөлөл.
8. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.
9. Хүний биед үзүүлэх сөрөг нөлөөлөл

**3.Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт:**

ШТС-ын үйл ажиллагааны явцад байгаль орчинд хохирол учруулж болзошгүй дараах нөлөөллүүдийг арилгаж, хамгаалж ажиллахад төслийн гол зорилго оршино.

- Технологи үйл ажиллагааны явцад техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг найдвартай хангаж гоожилт шүүрэлт асгалт үүсгэж хөрс, агаар, усны бохирдол үүсгэхгүй байхад анхаарч дэвшилт шинэ техник технологийг нэвтрүүлэх.
- Хүний санамсар болгоомжгүй үйлдэл гаргахгүй байхад ажилчдыг сургаж дадлагажуулах
- Газрын тосны бүтээгдэхүүнийг хэрэглэдэг автомашины яндангаас гарах хорт утаа нь шатахууны шинж чанараас хамааралтай байдаг тул олон улсын жишигт нийцсэн чанартай бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангаж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах

**Нөлөөлөлд өртөгдөх объект:**

- Тус агуулахын ажилчид, үйлчлүүлэгч-хүн, барилга байгууламж ба түүнийг хүрээлэн байгаа орчин.

---

**ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ****Агаар:**

- ШТС-ын төслийг хэрэгжүүлснээр агаарт тодорхой хэмжээний шатахууны уурын хольц, тээврийн хэрэгслийн утаа хаягдах ба бензин хальж асгарах, гоожсоноос үүдэн орчинд сөрөг нөлөөлөөд зогсохгүй түймэр, дэлбэрэлт үүсэх аюултай.
- ШТС-ын үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь нефтийн бүтээгдэхүүний ууршилт юм. Нефтийн бүтээгдэхүүний ууршилт нь шингэний гадаргуугаас уур үүсэх процесс бөгөөд өөрөөр хэлбэл шингэнээс уурын фазад шилжих үйл явц юм.
- Ууршилтыг дотор нь статик, динамик гэж 2 ангилж үзэж болно.
- Ууршиж байгаа шингэн ба хүрээлэн байгаа орчин нь бие биетэйгээ харьцангуй хөдөлгөөнгүй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг статик ууршилт гэх бөгөөд харин хөдөлгөөнтэй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг динамик ууршилт гэнэ.

**Ус:**

- Газар доорхи усанд нефтийн бүтээгдэхүүн алдагдвал удаан хугацаагаар хадгалагдаж, газар доорхи усны тархалтын талбайг хамарсан бохирдол үүсгэн, усан дахь хүчилтөрөгчтэй нэгдэн давирхайлаг бодис үүсгэн хар тугалга, хүнд металлын байнгын бохирдлын эх үүсгэврийг үүсгэдэг. Асгарсан, нэвчсэн шатахуун борооны ус, тогтоол усаар дамжин гүний усыг бохирдуулж болзошгүй. Бохирдол нь газар доорхи усны шилжилтийн дагуу тархаж хүрээгээ тэлэх ба түүнийг бүрэн цэвэршүүлэх боломжгүй болдог байна. Иймээс газар доорхи усанд нефтийн бүтээгдэхүүн алдагдахгүй байх бүхий л нөхцөл бололцоог хангасан байвал зохино.

**Хөрс, ургамал:**

- Шатахуун хадгалах сав ба холболтын хоолойнууд цоорох, бетон хучилт эвдрэх, бензин их хэмжээгээр хальж асгарсны улмаас хөрс нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болно.
- Хөрсөнд нэлээн удаан хугацаагаар хадгалагдаж, задарлынхаа явцад хөрсний үржил шим алдагдана.
- Хөрсний ялзмагийн бодисын хэмжээг багасгах
- 4 этилт хар тугалга бий болгон бохирдуулагч эх үүсвэр болгох
- \хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүний задарлаас үүдэн ургамлын өсөлт зогсох
- Ургамлын эд, эс мутацид орох
- Тухайн орчны хөрс ургамлын бүрхэвч устах хүртэл өөрчлөгдөнө.

## **АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УЧИРЧ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гарч болох сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: Жим харгуй олшрох, хөрс дагтарших, элэгдэл эвдрэлд орох, хөрс, хөрсний ус түүгээр дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасгах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, мод бут, өвс ургамал механик эвдрэл гэмтэлд өртөх гэх мэт сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй тул урьдчилан сэргийлэхийн тулд газрын тосны бүтээгдэхүүний агуулахын технологийн үйл ажиллагаанаас гарч болох хөдөлмөр хамгааллын дэглэмийг чанд сахих нь чухам юм.

## ОРЧНЫ ТОХИЖИЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үйл ажиллагааны үед байгалийн өнгө төрх өөрчлөгдөн ойр орчмын газрын хөрс, ургамлын нөмрөг технологи ажиллагаатай холбоотойгоор эвдрэлд орох зэргээр шууд бөгөөд урт хугацааны нөлөөлөл бий болох ч энэ нь цар хүрээ багатай байна. Иймд агуулахын талбайн хэмжээтэй тэнцэхүйц өөр талбайд, эсвэл сум, багийн нөхөн сэргээлт, мод, зүлэгжүүлэлт хийх шаардлагатай байгаа газарт ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэх ажлуудыг холбогдох ажилтан албан хаагчидтай хамтран хэрэгжүүлж болно.

## **ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ**

Газрын тосны бүтээгдэхүүнийг түгээх, тээвэрлэх, хадгалах явцад технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал нефтийн гаралтай бүтээгдэхүүний хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байна.

Газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, буулгах ажлыг ачаалал, хөл хөдөлгөөн харьцангуй багатай үед гүйцэтгэх нь тохиромжтой. Нефтийн гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, түгээхэд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд бэлэн байдлыг хангах, осол эрсдэлээс хамгаалах, хоргүйжүүлэх, саармагжуулах, гал унтраах арга хэмжээг шуурхай авах нөхцлийг бүрэн бүрдүүлэх шаардлагатай.

### **ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТ**

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм. Энэхүү агуулахын төслийн үйл ажиллагаанаас:

- Хатуу хог хаягдал
- Шингэн хог хаягдал
- Хийн хаягдал
- Машин техник, газрын тосны бүтээгдэхүүн асгарах түүнийг элс, шороо тусгай бодисоор цэвэрлэх үед гарах хог хаягдал гарна.

## **УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Төслийн үйл ажиллагаа болон нефтийн бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажилтан албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулахын тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай бүр төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан мөрдөж ажиллана.

## НИЙТ ЗАРДАЛ

| №    | Ажлын нэр                                                    | зардал    |
|------|--------------------------------------------------------------|-----------|
| 1    | Сөрөг нөлөөллээс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлын зардал | 400,000   |
| 2    | Орчины тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал      | 1,150,000 |
| 3    | Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал               | 220,000   |
| 4    | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал               | 400,000   |
| 5    | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал           | 2,200,000 |
| 6    | Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө                         | 420,000   |
| Нийт |                                                              | 4,790,000 |

**ОРХОН НЕФТЬ ХАНГАМЖИЙН САЛБАРЫН ХАРЪЯА ГТБ-ИЙ ЭРДЭНЭТ-АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**4.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                                                                                 | Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал /төг/      | Тоо хэмжээ | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                                                 |
|---|--------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-------------|---------------------------|------------|-----------------|------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|
|   | 1                                    | 2                                                                                                                                                                                                               | 3                             | 4           | 5                         | 6          | 7               | 8                            | 9                                                                                               |
| 1 | Агаарын чанарт сөргөөр нөлөөлөх      | Нефтийн бүтээгдэхүүн хөрс, ус, агаарт алдагдахаас урьдчилан сэргийлж сав, тоног төхөөрөмжийн битүүмжлэлийг хангаж ажиллах ба алдагдсан тохиолдолд элс, шохой, тусгай цэвэрлэгч бодис ашиглан ариутган цэвэрлэх. | ГТБ-ий агуулах                | Тухай бүрд  | Үйл ажиллагааны зардалаас | -          |                 | 2026 онд тогтмол             | ГТБ-ны агуулахын технологи, Агаарын тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага, |
|   |                                      | Зам талбайн орчинд цэвэрлэгээ, усалгаа хийх, авто машины явалтаар үүссэн тоосонцорыг зайлуулах.                                                                                                                 | ГТБ-ий агуулах                | Тогтмол     | Үйл ажиллагааны зардалаас | -          |                 | 2026 онд тогтмол             |                                                                                                 |
| 3 |                                      | Гадаад орчны зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, газрын тосны бүтээгдэхүүнийг буулгах, ачих талбайг тэмдэгжүүлэх, гадаад орчныг тохижуулах )         | ГТБ-ий агуулах                | Тогтмол     | Үйл ажиллагааны зардалаас | -          | -               | 2026 онд тогтмол             |                                                                                                 |

|          |                                                                   |                                                                                                                                                                                                                                                          |                |          |                            |   |   |          |                                                                                                                                          |
|----------|-------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------|----------------------------|---|---|----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 4        | Гадаргын болон газрын гүний усан орчинд сэргөөр нөлөөлөх          | Агуулахын үйл ажиллагаанд байнга хяналт тавих, нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах талбайд нефтийн бүтээгдэхүүн асгарсан байдалд хяналт тавих. Хөрс усанд нефтийн бүтээгдэхүүн нэвчиж болзошгүй хэсгийг засварлаж ажиллах.                              | ГТБ-ий агуулах | Тогтм ол | Үйл ажиллагаа ны зардалаас | - | - | 2026 онд | Усны тухай хууль, MNS4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага                                    |
|          |                                                                   | Нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд саармагжуулах ажлыг зохион байгуулах. Ахуйн бохир усыг хөрсөнд шууд асгахгүй байх талаар ажилчдад анхааруулж байх. Асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах. | ГТБ-ий агуулах | Тогтм ол | Үйл ажиллагаа ны зардалаас | - | - | 2026 онд |                                                                                                                                          |
| 5        | Эрүүл мэндэд сэргөөр нөлөөлөх                                     | Ажилчдын байрны ариутгал цэвэрлэгээг хийх. Ажилчдад зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж цэвэрлэх.                                                                                                           | ГТБ-ий агуулах | ш        | Үйл ажиллагаа ны зардлаас  | - | - | 2026 онд | ХАБЭА-н тухай хууль                                                                                                                      |
| 6        | Хөрсөн бүрхэвч, газрын гадарга, ургамлын нөмрөгт сэргөөр нөлөөлөх | Зам талбайн орчинд цэвэрлэгээ, усалгаа хийх, авто машины явалтаар үүссэн тоосонцорыг зайлуулах.                                                                                                                                                          | ГТБ-ий агуулах | ш        | Үйл ажиллагаа ны зардлаас  | - | - | 2026 онд | MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5342:2007 Автомашины зогсоол ангилал, ерөнхий шаардлага |
| 7        |                                                                   | Гадаад орчны зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, газрын тосны бүтээгдэхүүнийг буулгах, ачих талбайг тэмдэгжүүлэх, гадаад орчныг тохижуулах )                                                  | ГТБ-ий агуулах | ш        | Үйл ажиллагаа ны зардлаас  | - | - | 2026 онд |                                                                                                                                          |
| Нийт дүн |                                                                   |                                                                                                                                                                                                                                                          |                |          |                            |   | - | 400,000  |                                                                                                                                          |

## 5.Орчны тохижилт,нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт                                                                                                                                                          | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                                                                                                                            | Арга хэмжээний цар хүрээ | Хэмж их нэгж     | Тоо хэм жээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг                |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|------------------|-------------|---------------------|-----------------|------------------------------|------------------------------------------------|
|   | 1                                                                                                                                                                                                  | 2                                                                                                                                                        | 3                        | 4                | 5           | 6                   | 7               | 8                            | 9                                              |
| 1 | МУ-ын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлигийн дагуу Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2026 оны хавар, намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр орон нутгаас зааж өгсөн газарт мод тарих | Хавар, Намрын бүх нийтээрээ мод тарих ажлын хүрээнд Орхон аймгийн БОГ-аас зааж өгсөн газарт 1,5м-с дээш өндөртэй Агч мод нийт 50ш тарьж арчилж ургуулах. | ГТБ-ий агуулах           | ш                | 50          | 20 000              | 1 000 000       | 5,10 сард 2 удаа             | МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг |
| 2 |                                                                                                                                                                                                    | Баян-Өндөр уулын урд энгэрийн ногоон төгөлд байх 2021, 2022, 2023,2024,2025 онд тарьсан модны цэнэг усалгаа арчилгааг хийж арчилж ургуулах.              | ГТБ-ий агуулах           | ш                | 2           | 50 000              | 100 000         | 5,10 сард 2 удаа             |                                                |
| 3 |                                                                                                                                                                                                    | Орон нутгаас зохион байгуулж буй байгаль орчныг хамгаалах сургалтанд хамрагдах.                                                                          | ГТБ-ий агуулах           | -                |             | Зардал гарахгүй     | -               | 2026 онд                     |                                                |
| 4 |                                                                                                                                                                                                    | Агуулахын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд цэцгийн мандал хийж цэцэг тарих ногоон байгууламж байгуулах.                                            | ГТБ-ий агуулах           | 50M <sup>2</sup> | 1           | 50 000              | 50 000          | 5,6 сард                     |                                                |
|   | Нийт                                                                                                                                                                                               |                                                                                                                                                          |                          |                  |             |                     | 1 150 000 төг   |                              |                                                |

**6.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

ШТС-ын эзэмшил талбайд түүх, соёлтой холбоотой эд зүйл байхгүй болно.

**7.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл                                                       | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ                                                                                                                                                                       | Арга хэмжээн ий цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал,төг     | Нийт зардал төг                      | Хэрэгжү үлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                                  |
|---|--------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|------------|------------------------|--------------------------------------|-------------------------------|----------------------------------------------------------------------------------|
|   | 1                                                                                          | 2                                                                                                                                                                                                                | 3                           | 4          | 5                      | 6                                    | 7                             | 8                                                                                |
| 1 | Газрын тосны бүтээгдэхүүийг ачих, буулгах, тээвэрлэх үед орчинд алдагдах, тархах           | Байнгын хяналт тавих ба шаардлагатай үед алдагдсан газрын тосны бүтээгдэхүүнийг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах.                                                                                        | ГТБ-ий агуулах              | -          | -                      | Үйл ажиллагаа ны зардлаас тухай бүрт | 2026 онд                      | ГТБ-ны агуулахын технологи                                                       |
| 2 | Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах                 | Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх.Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол өгч байх. | ГТБ-ий агуулах              | -          | -                      | Үйл ажиллагаа ны зардлаас тухай бүрт | 2026 онд                      |                                                                                  |
| 3 | Газрын тосны бүтээгдэхүүн алдагдах, асгарах зэргээр ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулах | Ажилчдад зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж цэвэрлэх. Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох.                                                                        | ГТБ-ий агуулах              | -          | Үйл ажиллагааны зардал | -                                    | 2026 онд                      | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй, Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага |
|   | <b>Нийт</b>                                                                                |                                                                                                                                                                                                                  |                             |            |                        | <b>220,000</b>                       |                               |                                                                                  |

## 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал            | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                                                                                            | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг    | Тоо хэмжээ | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                                                                                      |
|---|---------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-------------|------------------------|------------|-----------------|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | 1                               | 2                                                                                                                                                                                                                          | 3                             | 4           | 5                      | 6          | 7               | 8                   | 9                                                                                                                                    |
| 1 | Ахуйн болон аюултай хог хаягдал | Ахуйн болон аюултай хог хаягдал ангилан ялгаж тусгай саванд хадгалж ХТГ-тай байгуулсан гэрээний дагуу цаг тухай бүрт нь ачуулж хоггүй цэвэр орчинг бүрдүүлэх. Эрх бүхий газартай “Аюултай хог хаягдлын гэрээ”-г байгуулах. | ГТБ-ий агуулах                | сар         | 20 000                 | 12         | 240 000         | 2026 онд            | Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/ Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам |
| 2 |                                 | ГТБА-ын ойр орчмын 50 метр дотор цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж ажиллах /Зэрлэг өвс, ургамал, цас мөсийг арилгаж орчны цэвэрлэгээ болон аюулгүй байдлыг хангах.                                                          | ГТБ-ий агуулах                | -           | Үйл ажиллагааны зардал | Тогтмол    | -               | 2026 онд            |                                                                                                                                      |
| 3 |                                 | Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд хийгддэг бүх нийтийн цэвэрлэгээнд нийт ажилчдыг хамруулах.                                                                                                                            | Эзэнгүй хог хаягдалтай газар  | Жилд 2 удаа | 80 000                 | 2          | 160 000         | Хавар, Намар        |                                                                                                                                      |
|   | Нийт                            |                                                                                                                                                                                                                            |                               |             |                        |            | 400.000 төг     |                     |                                                                                                                                      |

## 9.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг    | Тайлбар                      | Баримтлах эрх зүйн баримт бичиг                               |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|--------------------|----------------|---------------------|--------------------|------------------------------|---------------------------------------------------------------|
|   | 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 2                       | 3                  | 4              | 5                   | 6                  | 7                            | 8                                                             |
| 1 | Эрдэнэт агуулахын ойр орчны хөрсөнд MNS5850:2019 (органик болон органик биш элементүүд хөрсний механик болон бусад үзүүлэлтүүд дотроо хүнд метал хар тугалга, мишьёок,цайр,газрын тосны бүтээгдэхүүний агууламжуудыг болон Эко нойлны ойр орчимоос нянгийн шинжилгээ) мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж жилд 1 удаа шинжилгээ хийлгэж гарсан шинжилгээний дүнг холбогдох төрийн байгууллагуудад тайлагнаж ажиллах /БОГ/ | ГТБ-ий агуулах          | 2026 онд 1 удаа    | 1              | 420 000             | 420 000            | Тодорхой цэгүүдээс дээж авах | БОУАӨЯ-ын сайдын 2019 оны 5-р сарын 06-ны А/164 дугаар тушаал |
| 2 | Эрдэнэт агуулахын ойр орчны агаарт MNS4586:2016 (аммиак, хүхэрт устөрөгч, бензол, ксилолууд, толуол, формальдегид, азотын давхар исэл, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн давхар исэл, угаарын хий, болон РМ 2.5, РМ 10, нийт тоосонцор) мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж жилд 1 удаа шинжилгээ хийлгэж гарсан шинжилгээний дүнг холбогдох төрийн байгууллагуудад тайлагнаж ажиллах / БОГ/                                   | ГТБ-ий агуулах          | 2026 онд 1 удаа    | 1              |                     |                    | Тодорхой цэгүүдээс дээж авах |                                                               |
| 3 | Эрдэнэт агуулахын ойр орчмын усанд MNS4943:2015 (усан дахь устөрөгчийн илтгэгч РН, цайр, кадми, хар тугалга, хүнцэл, хүнд металын үзүүлэлтүүд) мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж жилд 1 удаа шинжилгээ хийлгэж гарсан шинжилгээний дүнг холбогдох төрийн байгууллагуудад тайлагнаж ажиллах /БОГ/                                                                                                                        | ГТБ-ий агуулах          | 2026 онд 1 удаа    | 1              |                     |                    | Тодорхой цэгүүдээс дээж авах |                                                               |
|   | <b>Нийт</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                         |                    |                |                     | <b>420 000 төг</b> |                              |                                                               |

## 10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| №    | Төлөвлсөн арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                       | Урьдчилан тооцсон төсөв  | Хэрэгжүүлэх хуваарь 2026 он |          |          | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар                                                                                                                                                       |
|------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----------------------------|----------|----------|---------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|      |                                                                                                                                                                                                                                                                             |                          | Сар.....                    | Сар..... | Сар..... |                           |                                                                                                                                                               |
|      | 1                                                                                                                                                                                                                                                                           | 2                        | 3                           | 4        | 5        | 6                         | 7                                                                                                                                                             |
| 1    | Орхон аймгийн БОГ-ын холбогдох мэргэжилтэнгээс БОУАӨЯ -ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний А/618 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын талаар заавар зөвлөгөөг авч 2026 оны БОМТ боловсруулж хянан батлуулж ажиллах. | Үйл ажиллагааны зардлаас | 1-р сард                    |          |          | ХАБЭА-н инженер, Эрхлэгч  | БОУАӨЯ -ын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаал                                                                                                                |
| 2    | Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний биелэлт тайланг гаргаж цаг хугацаанд нь тайлагнаж ажиллах.                                                                                                                                                                | Үйл ажиллагааны зардлаас | 11 сарын 01-ний дотор       |          |          | ХАБЭА-н инженер, Эрхлэгч  |                                                                                                                                                               |
| 3    | Нийт ажилчдыг эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт жилд 1 удаа хамруулах.                                                                                                                                                                                                           | Үйл ажиллагааны зардлаас | 10-11 сард                  |          |          | ХАБЭА-н инженер, ЗХНА     | “Хөдөлмөрийн аюулгүй байдал,Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688:2000<br>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй, Ажлын тусгай хувцас- Ерөнхий шаардлага |
| 4    | Нийт ажилчдад аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохион байгуулж байх.                                                                                                                                                                                                     | Үйл ажиллагааны зардлаас | Улирал бүр                  |          |          | ХАБЭА-н инженер           |                                                                                                                                                               |
| Нийт |                                                                                                                                                                                                                                                                             |                          |                             |          |          | 2,200,000                 |                                                                                                                                                               |

11.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| № | БОМТ,БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд  | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга                             | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг         | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан/                              | Зохион байгуулах газар |
|---|---------------------------------------------------------|------------------|------------------------------------------------|--------------------------------|-------------------------------|----------------------------------------------------------------------------------|------------------------|
|   | 1                                                       | 2                | 3                                              | 4                              | 5                             | 6                                                                                | 7                      |
| 1 | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн иргэд. | Цахим хэлбэрээр  | Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө | 10 сард                        | Дотоод үйл ажиллагааны зардал | "НИК" ХХК-ийн Орхон нефть хангамжийн салбарын агуулахын эрхлэгч, ХАБЭА-н инженер |                        |
|   | Нийт                                                    |                  |                                                |                                | -                             |                                                                                  |                        |